



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/67

Улаанбаатар хот

“Сэтгэл зүйн дархлааг дэмжье” аяныг  
Хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулах тухай

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 1.2 дахь заалтуудыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд “Хотын соёл” аяныг хүрээнд, Нийслэлийн засаг даргын тамгын газрын 2021 оын 06 сарын 21-ний 03/2482 тоот аяны удирдамжийг хэрэгжүүлэх, эмч ажилчдын стресс, ачаалалыг буруулах “Сэтгэл зүйн дархлааг дэмжье” арга хэмжээг зохион байгуулах зорилгоор ТУШААХ нь:

1. Эмч ажилчдын ажлын сэтгэл санааг дэмжих, стресс буруулах зорилгоор 2021 оны 11 сарын 15-наас 12 сарын 15-ны хүртэл “Сэтгэл зүйн дархлааг дэмжье” арга хэмжээг зохион байгуулан төлөвлөгөө гарган, зохион байгуулах ажлын хэсгийг доорхи бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Ц.Энхбаясгалан - Хүний нөөцийн албаны дарга

Нарийн бичиг: Г.Бүжидмаа- Сэтгэл зүйч

Ажлын хэсгийн ахлагч: Э.Пүрэвсүрэн - Сэтгэцийн их эмч

Гишүүд: Дэлгэрмаа- Аж ахуйн дарга

Ариунжаргал- тархвар судлаач эмч

М.Болдбаатар-Гэмтлийн их эмч

С.Солонго- Хавдрын их эмч

А.Амартөвшин- МТАлбаны дарга

Болор-Эрдэнэ- Шүдний их эмч

Б.Алтанбагана- Цахим бүртгэлийн ажилтан

2. “Сэтгэл зүйн дархлааг дэмжье” аяны хүрээнд төлөвлөгөө, төсөвийг хавсралтаар баталсугай.

3. “Жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх” аяны хүрээнд “Хүчирхийлэл хүн бүхэнд хамаатай” уриан дор төлөвлөгөөг хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар Хан-Уул дүүргийн засаг даргын тамгын газарын Нийгмийн Хөгжлийн хэлтэст 2021 оны 12 сарын 13-ны дотор тайланг хүргүүлэхийг Ажлын хэсгийн дарга /Ц.Энбаясгалан/, нарийн бичиг /Д.Бат-Эрдэнэ / нарт даалгасугай.

ДАРГА

Э.БОДЬЦЭЦЭГ

Хан-Уул эрүүл мэндийн төвийн даргын  
2021 оны ..... дугаар сарын .....-ны өдрийн  
..... тоот тушаалын хавсралт

2021 оны 11-р сарын 10-ны өдөр

### “Сэтгэл зүйн дархлааг дэмжье” аяны удирдамж

**Зорилго:** Ковид-19-ийн халдварын эсрэг эмч эмнэлгийн албан хаагчид өнөөдрийг хүртэл амаргүй нөхцөл байдалд мөр зэрэгцэн ажиллаж байна. Эмч ажилчид ажлын ачаалал нэмэгдэж, өдөр тутмын ажил, амьдрал халдварын нөхцөл байдлаас шалтгаалж ихээхэн өөрчлөлт орсноор бухимдах, уурлах, ажлаас халшрах хам шинж, стресстэх гэх мэт сэтгэл зүйн байдлыг үнэлэн судалгаа авч Сэтгэл зүйн дархлааг дэмжих зорилгоор 1 сарын аян зохион байгуулан тасаг нэгжийн уур амьсгалыг өөрчлөх, баг хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор зохин байгуулж байна.

**Үндэслэл:** Сэтгэцийн эрүүл мэндийн наркологийн кабинетаас 2019 онд ажилчдын дунд сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг илрүүлэх зорилгоор дараах судалгааг хийж үр дүнг харахад:

Судалгаанд нийт 67 хүн хамрагдсанаас эмч-23 хүн, сувилагч-24 хүн, бусад эмнэлгийн мэргэжилтэн 20 хүн тус тус хамрагдсан байна.

Судалгааны үр дүн:

1. Сэтгэл гутралын түвшинг тодорхойлох Бекийн сорил
  - 0-10 оноо хэвийн 52 хүн буюу 77,6%
  - 11-17 оноо хөнгөн сэтгэл гутрал 10 хүн буюу 14,9%
  - 18-23 оноо дунд зэргийн сэтгэл гутрал 1 хүн буюу 1,5%
  - 24-өөс дээш оноо 2 хүн буюу 2,9%
2. Неврозын түвшинг үнэлэх сорил
  - 1 дэхь асуултанд тийм гэж хариулсан бол өөрийгөө нойрны ям
  - 20-44 оноо хэвийн 57 хүн буюу 85%
  - 45-59 оноо дунд зэргийн сэтгэл түгшилт 1 хүн буюу 1,5%
3. Нойргүйдлийг илрүүлэх сорилд
  - Нойрны хямралгүй-23 хүн буюу 34,32%
  - Санаа зовохоор асуудалтай биш-3 хүн буюу 4,47%
  - Нойрны ямар нэгэн хямралтай- 5 хүн буюу 7,46%
  - Нойрны хямралтай- 27 хүн буюу 40,29%
4. Сэтгэл түгшилтийн төрөлхийн байдлыг тодорхойлох спилберг-ханины сорил
  - Сэтгэл түгшилт бага-16хүн буюу 23.88%
  - Сэтгэл түгшилт дунд -38 хүн 56.71%

➤ Сэтгэл түгшилт өндөр-7 хүн 10.44%

Судалгаанаас харахад ажилчдын дунд нойрны хямрал өндөр буюу 40.29% байна. Сэтгэл гутралын үнэлгээгээр хөнгөн зэргийн сэтгэл гутрал 10 хүн буюу 14.49%, дунд зэргийн сэтгэл гутрал 1 хүн буюу 1.49%, гүнзгий сэтгэл гутрал -2 хүн буюу 2.98% байна. Мөн сэтгэл түгшилт дунд зэргийн -56.71%, сэтгэл түгшилт өндөр зэрэг-10.44% байгаа нь цаашид ажилчдын сэтгэцийн эрүүл мэндийн хамгаалах, дэмжих чиглэлийн үйл ажиллагаа хэрэгцээтэй байгааг харуулж байна.

**Үйл ажиллагааны чиглэл:**

Байгууллагын ажилчдад чиглэсэн үйл ажиллагаа

**Хамрах хүрээ:** ХУЭМТ-ийн эмч, эмнэлгийн ажилчдад

**Хугацаа:** 2021.11.15-.12.1-15 1 сарын хугацаанд

**Зохион байгуулагч:** ХУЭМТ

**Хамтран ажиллах:** ХУДЭМТ-н тасаг нэгжүүд

**Хүрэх үр дүн:** Сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол нэмэгдэж, сэтгэцийн тулгамдсан асуудлын талаархи мэдлэг дээшилнэ. Байгууллагын эмч, эмнэлгийн ажилчдын ажлын байрны стресс буурч сэтгэл зүйн эерэг уур амьсгалыг бүрдүүлнэ.

**“СЭТГЭЛ ЗҮЙН ДАРХЛААГ ДЭМЖЬЕ” АЯНЫ ХҮРЭЭНД ХИЙГДЭХ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хийгдэх үйл ажиллагаа	Хугацаа	Хариуцах эзэн
1.	“Сэтгэл зүйн дархлааг дэмжье” аяны арга хэмжээний мэдээлэл, хүний нөөцийн албаны мэдээлэл, шинэ ажилчдын танилцуулга тус тус хийгдэх	2021.11.16- 2021.11.18	Хүний нөөцийн алба Ажлын хэсэг
2.	Байгууллагын бүх ажилчдаас ажлаас халшрах хам шинжийн судалгааг авч нэгтгэх	2021.11.16- 2021.11.18	Сэтгэц, Наркологийн кабинет
3.	Ажиллагсдын хандлага-харилцаа, ёс зүйг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг тогтмол зохион байгуулах, дэмжлэгт удирдлагаар хангах	2021.11.15- 2021.12.15	Б.Баярцэцэг Ёс зүйн хорооны дарга Ёс зүйн хэсгийн хороо
4.	“Сэтгэл зүйн дархлааг дэмжье” сургалт зохион байгуулах	2021.12.10	Ажлын хэсэг Лектор Чила
5.	Спортын уралдаан тэмцээн зохион байгуулах /Болейвол, дардасын тэмцээн/	2021.12.11	Тасаг нэгжийн дарга нар Ажлын хэсэг
6.	“Бүжгийн хичээл”	2021.11.15- 2021.12.15	Бүжгийн багш
7.	“Дагаад дуулаарай” видео бичлэг	2021.11.22- 2021.11.26	Ажлын хэсэг
8.	Аяны үр дүнг нэгтгэх зорилгоор судалгаа авах	2021.12.16	Ажлын хэсэг

**“СЭТГЭЛ ЗҮЙН ДАРХЛААГ ДЭМЖЬЕ” АЯНЫ ХҮРЭЭНД ХИЙГДЭХ ҮЙЛ  
АЖИЛЛАГААНЫ ТӨСӨВ**

№	Утга	Тоо	Үнэ	Нийт
1	“Сэтгэл зүйн дархлааг дэмжье” аяны арга хэмжээний мэдээлэл, хүний нөөцийн албаны мэдээлэл, шинэ ажилчдын танилцуулага /хүн бүр бейкери /	217	1500	330.000
2	Сэтгэл зүйн сургалт зохион байгуулах	2 цаг	300000	600.000
	Хөгжөөнт тэмцээн зохион байгуулах	3 хүн	20000	70.000
3	Спортын уралдаан тэмцээн зохион байгуулах	1-р байр	350000	1.050.000
		2-р байр	250000	
		3-р байр	150000	
4	Дардас тэмцээн	эрэгтэй 1-р байр	150000	
		эмэгтэй 1-р байр	150000	
	Ус, ундаа, өргөмжлөл		100000	100.000
5	Шүүгчийн төлбөр		200000	200.000
6	Бүжгийн багш	1 багш	400000	400.000
	<b>Нийт</b>			<b>2.750.000</b>